



MGL AQUA

**“ЭМ ЖИ ЭЛ АКУА” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 03-ны өдөр

№ 26/01

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйл, иргэний хуулийн 62, 64 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ти Эм Эл” группын хамаарал бүхий “Ти Эм Эл” ГХОХХК нь Худалдаа, хөгжлийн банктэй 2017 оны 02 сарын 06-ны өдрийн №3Г/СС170203002-1 тоот зээлийн гэрээг байгуулж, China development bank-ны эх үүсвэртэй зээлийг дараах нөхцлөөр авч ашиглаж байна. Үүнд:

- Дүн: 40,000,000.00 CNY
- Хугацаа: 59 сар
- Хүү: жилийн 10%


Дээр дурдсан зээлийг тус гэрээний дагуу 2026 оны 02-р сарын 27-ны өдөр Худалдаа, хөгжлийн банкны эх үүсвэртэй зээлд дор дурдсан дүнгээр, 1 сарын хугацаатай, жилийн 12%-н хүүтэй зээлд шилжүүлсэн бөгөөд тус зээлийг дахин Bank of Inner Mongolia-н эх үүсвэртэй зээлд дараах нөхцлөөр өөрчлөлт оруулж, сунгахыг зөвшөөрсүгэй.

- Дүн: 1,147,282.37 USD-г гэрээ баталгаажих өдрийн ХХБ-ны кросс ханшид тооцон 8 сая юань
- Bank of Inner Mongolia-н эх үүсвэртэй зээлийн хүү: жилийн 13.26 %
- Хугацаа: 12 сар /Зөвхөн Bank of Inner Mongolia-н эх үүсвэртэй зээлийн хувьд/

2. Энэ тогтоолын нэгдүгээр зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “Эмжи эл акуа” ХК-ийн өмчлөлийн Ү-2201012113, Ү-2201010641 тоот дугаартай үл хөдлөх хөрөнгө, Э-2201038768 улсын бүртгэлийн дугаартай газрыг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын 1,2,3 дугаар зүйлд заасан шийдвэрийн дагуу Худалдаа, хөгжлийн банктэй байгуулах Зээлийн нэмэлт гэрээнд гарын үсэг зурах, компанийг төлөөлж гэрээ, хэлцэл байгуулах болон нотариатчаар гэрчлүүлэхтэй холбогдсон бүхий л үйл ажиллагаанд компанийг төлөөлөх гарын үсэг зурах эрхийг компанийн ТУЗ-н ердийн гишүүн Батбаяр овогтой Ундрал /№ ТЖ82081772/-д олгохоор шийдвэрлэв.

4. Энэхүү тогтоолоор компанийн ТУЗ-н ердийн гишүүн Батбаяр овогтой Ундрал /регистрийн №ТЖ82081772/-д олгосон эрх нь тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй байна.

ТУЗ-н дарга  Д.БИЛГҮҮН